

## **Компанийн 2017 оны ажлын тайлан**

- 1. Компанийн нэр: Техник импорт ХК**
- 2. Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-125**
- 3. Утас: 70001830**
- 4. Регистрийн дугаар: 2057239**
- 5. Компанийн үйл ажиллагааны чиглэл: Гадаад худалдаа, барилгын материал үйлдвэрлэл, түрээс**

### **1. Компанийн бизнесийн үйл ажиллагаа**

Манай компани тайлант хугацаанд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан “2017 оны бизнес төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхээр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн бодлого, чиглэлийн дагуу компанийн бизнес үйл ажиллагааг дараахь үндсэн чиглэлээр зохион байгуулж хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

1. Цемент болон цементийн түүхий эдийг компанидаа болон өөрийн охин компаниудад нийлүүлж харилцагч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийн захиалгаар худалдан борлуулах, нийлүүлэх
2. ОХУ-аас импортолсон, ОУ-ын чанар, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн /хөргөгч, хөлдөөгч, угаалгын машин, хөнгөн цагаан хийцийн гэр ахуйн сав, суулга, замын битум/-ийг худалдан борлуулах
3. Мотоцикл, мотоциклийн сэлбэг хэрэгслийг импортолон аймаг, хот, хөдөөд болон өөрийн компанийн нэрийн барааны дэлгүүрүүдээр худалдан борлуулах
4. Өөрийн эзэмшлийн байрыг ажлын байрны зориулалтаар аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүст түрээслүүлэх

Тайлант хугацаанд компаниас бизнесийн үйл ажиллагаагаа явуулахтай холбогдуулан дараахь чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

1. Компаниас хэрэглэгч, харилцагч, үйлчилгээг сайжруулах, бараа, материалыг сурталчлах, худалдан борлуулах, нийлүүлэх, хүргэх, тээвэрлэх, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч компанийн албадын ажлын уялдаа холбоог сайжруулж бүх ажилчдын ажлын зохион байгуулалт, хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагыг өндөржүүлж компанийн хэмжээнд мөрдөгдөж байгаа холбогдох хууль, дүрэм, журмыг ажил, үйлчилгээндээ баримталж ажиллаж байгаа эсэх, удирдлагаас өгч байгаа үүрэг, даалгаврын хэрэгжилтэнд цаг тухайд нь хяналт тавьж ажилласан.

2. Улс оронд бий болсон эдийн засгийн хямралтай байгаа нөхцөл байдалтай холбогдуулан компанийн үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэн ажиллах, компаниас аливаа үйл ажиллагааг явуулахтай холбогдуулан түүнд тавих санхүүгийн сахилга батыг өндөржүүлэх, хяналт шалгалт, хариуцлагыг сайжруулах, компанийн хэмжээнд мөрдүүлэх шаардлагатай холбогдох дүрэм, журмыг боловсруулж хэрэгжүүлэх, 2016 оны компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан өр авлагыг яаралтай барагдуулах, төлөгдөхгүй байгаа авлагыг шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлж авлагыг баталгаажуулах, банкны зээлийн эргэн төлөлтийг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх, компанийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй, тогтвортой явуулахад онцгой анхаарч ажилласан.
3. Компанийн ажилчид болон түрээслэгчдийн тав тухтай ажиллах нөхцөл, байдлыг хангаж ажиллахад анхаарч **374 700** төгрөг зарцуулж компанийн барилгын сантехникийн засвар, үйлчилгээний ажлыг цаг хугацаанд зохион байгуулж хийлгэн өвлийн бэлтгэлийг сайтар хангаж ажилласны үр дүнд компанийн хэмжээнд халаалт, дулаан хэвийн явагдаж ямар нэгэн догоилдол гаргалгүй ажилласан.
4. Компанийн зарим өрөөнүүдэд байгаа эvdэрч, ашиглах боломжгүй болсон зарим төрлийн тавилга, эд хогшлыг солих, шинэчлэхэд зориулж **8 644 000** төгрөг зарцуулсан.
5. Компанийн дотоод үйл ажиллагаанд явдаг машиныг сольж шинээр машин худалдан авахад зориулж **10 900 000** төгрөг зарцуулсан.
6. Төрийн байгууллагаас баталсан холбогдох журмыг үндэслэн хотын замын түгжрэл, saatlyig bagasgah, компаниар үйлчлүүлэгчдийн автомашиныг байрлуулах, газар, талбайн ашиглалтыг сайжруулах зорилгоор компанийн эзэмшлийн баруун болон баруун хойд хэсгийн газрыг тэгшилж асфальтан зам тавьж, автозогсоолын төмөр хашаа, замын тэмдэглэгээ, зам, талбайн тохижилтын ажлыг хийхэд компаниас **210 097 716** төгрөг зарцуулж өөрийн зардлаар хийж гүйцэтгэн ашиглалтанд бүрэн оруулж ажилласан.
7. Холбогдох байгууллагаас баталсан журамд үндэслэн компаниас автомашины төлбөртэй зогсоолын үйлчилгээг эрхлэн явуулах, төлбөртэй зогсоолын үйл ажиллагаанд ашиглагдах тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулж **10 375 000** төгрөг зарцуулсан.
8. Компанийн борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, компанийн бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэгч үйлчлүүлэгчид таниулах, сурталчлах, үйл ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлээр “Нарantuул” ОУ-ын худалдааны төвд салбараа нээхтэй холбогдуулан харуулын байрыг барихад зориулж **2 000 000** төгрөг зарцуулсан.
9. Компанийн санхүүгийн албаны үйл ажиллагааг түргэн шуурхай явуулах, санхүүгийн программ хангамжийг сайжруулах зорилгоор санхүүгийн ажилчдын албаны хэрэгцээнд зориулж шинээр компьютер худалдан авахад **13 900 000** төгрөг зарцуулсан.

10. Компанийн захиалгаар импортолсон буюу харилцагч байгууллагаас нийлүүлсэн бараа материал, компанийн эзэмшийн өмч, эд хөрөнгийг бүрэн бүтэн хадгалж хамгаалах, компаниас бараа, материал гаргах, зөөх, тээвэрлэхэд хяналт тавих, компанийн дотоод үйл ажиллагаанд болон гадна орчинд аюулгүй байдлыг хангахад компанийн харуул хамгаалалтын алба нь онцгой чухал үүрэг гүйцэтгэж ажилладаг бөгөөд компанийн харуулын албаны ажлыг чанаржуулж ажиллуулахад ихээхэн анхаарч тодорхой чиглэлээр зөвлөмж, үүрэг өгч ажилласан. Харуулуудын ажлын уялдаа холбоог сайжруулахад зориулж станцуудын засвар, үйлчилгээнд **115 500** төгрөг зарцуулсан.
11. Хот, дүүрэг болон компанийн удирдлагаас зохион байгуулсан 2 удаагийн цэвэрлэгээ, тохижилтын ажилд компанийн ажилчдыг бүрэн хамруулж оролцуулсан.
12. Компанийн ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцсыг худалдан авах, цэвэрлэгээний бодис, бусад материал худалдан авахад зориулж **11 500 000** төгрөг зарцуулсан
13. Компанийн ажилчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, ажилчдын эрүүл мэндийг сайжруулах зорилгоор зуны болон өвлийн улиралд 2 удаа амралтын өдрөөр хотоос гарч салхинд гарах ажлыг компаниас жил бүр уламжлал болгон зохион байгуулж явуулдаг ба тайлант хугацаанд компанийн нийт ажилчдыг хамруулж “Их хуралдай” амралтын газар явуулж амраасан.
14. Компанийн дотоод аудитын албаар сар бүр компанийн болон охин компаниудын санхүү, бусад үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу хяналт тавиулж үйл ажиллагаанд зөрчил дутагдал гаргасан, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг биелүүлээгүй тохиолдолд биелүүлэх талаар холбогдох компанийн албан тушаалтанд хугацаатай үүрэг, даалгавар өгч хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажилласан.
15. Жил бүрийн 12 сард компанийн удирдлага ажилтнуудын хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, ажлын үр дүнг албадын удирдлагуудтай хэлэлцэн дүгнэж тухайн жилийн ажлын тайланг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд тайлагнадаг. Тайлант хугацаанд удирдлагаас 2017 оны ажлын үр дүнг дүгнэж идэвх зүтгэлтэй, үр бүтээлтэй ажилласан компанийн 4 ажилтныг “Тайланд улсаар аялах эрхийн бичиг”-ээр, 2 ажилтныг “ОХУ-ын Улаан-Үд хотоор аялах эрхийн бичиг”-ээр тус тус шагнаж урамшуулсан.
16. Жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг “Ахмадын өдөр”-өөр компани Техник импорт ХК-ийн түүхийг бүтээлцэж залуу нас, эрдэм, мэдлэгээ зориулж компанийн хөгжил, дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж хөдөлмөрлөсөн ахмадуудаа хүлээн авч тэдэнд хүндэтгэл үзүүлсэн.
17. Хот, дүүрэг болон компанийн удирдлагаас зохион байгуулсан 2 удаагийн цэвэрлэгээ, тохижилтын ажилд компанийн ажилчдыг бүрэн хамруулж оролцуулсан. 2017 онд энэхүү ажлын хүрээнд компаниас хог, ачих тээвэрлэх ажилд нийт **2 080 000** төгрөг зарцуулсан.

**Санхүүгийн чиглэлээр:**

Тайлант хугацаанд компани санхүүгийн тайлан, аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогын, үл хөдлөх эд хөрөнгийн, авто тээвэр өөрөө явах хэрэгслийн, нэмэгдсэн өртгийн албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог хуулиар тогтоосон хугацаанд гаргаж харилцагч дүүргийн санхүү, татвар, нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан ба тайлангийн хугацаанд:

- Улсын төсөвт 6 тэрбум 9,3 сая төгрөг
- ААНОА татварт- 68,8 сая төгрөг
- НӨАТ-т 5 тэрбум 762 сая төгрөг
- НДШ-д 111,0 сая төгрөг
- ХХОАТ-т 42,9 сая төгрөг
- Бусад татварт- 24,6 сая төгрөг тус тус төлсөн.

Тайлант хугацаанд компаниас бизнесийн үйл ажиллагааг зохион байгуулж явуулахад улс орны эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал сөргөөр нөлөөлж байсан ч компанийн болон охин компаниудын аливаа үйл ажиллагаан дах ажлын зохион байгуулалт, хөдөлмөрийн сахилга батыг өндөржүүлж түүнд тавих хяналт, хариуцлагыг сайжруулж ажилласнаар компаниудын үйл ажиллагаа хэвийн, доголдолгүй, ажилчдын цалин хөлсийг цаг хугацаанд нь олгож ажиллалаа.

## 2. Компанийн удирдлага, зохион байгуулалт

### Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл

Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн удирдлагыг хэрэгжүүлдэг бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн “Дүрэм” болон “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-аар олгосон эрхүүргийн хүрээнд компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан шийдвэр, тогтоолыг хэрэгжүүлэх, компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, компанийн удирдлагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаатай уялдуулан ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор Нэр дэвшүүлэх, Аудитын болон Цалин урамшууллын хороог байгуулж ажилласан ба хороодын гишүүд хамрах асуудал, чиг үүргийн хүрээний дагуу компанийн гүйцэтгэх удирдлага, албадын дарга нараас өөрсдийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай холбогдох мэдээлэл, баримт материалыг авч судалж боловсруулан ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлж гарсан шийдвэрийн дагуу ТУЗ-аас зөвлөмж, үүрэг, даалгаврыг компанийн удирдлагад өгч хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллалаа.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл компанийн бизнес үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, санхүүгийн үйл ажиллагааны явц, байдлын талаар компанийн Гүйцэтгэх удирдлагаас сар тутам тайлангаар авч хянан, холбогдох үүрэг, чиглэл өгч ажилласан.

Тайлант хугацаанд компанийн ТУЗ-ын ердийн гишүүнээр Д.Баяраа, Э.Батболд, С. Бүжинлхам, Г.Уран-Өлзий, Л. Уртнасан, Т. Тунгалаг, хараат бус гишүүнээр Ж. Баярсайхан, Б.Нарантуяа, Б.Батсайхан, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Т.Тунгалаг, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар О. Бүжинлхам, компанийн Гүйцэтгэх захирлаар Д. Ганцэцэг ажилласан.

Тайлант хугацаанд компанийн ТУЗ нь 2017 оны ХЭХ-аас баталсан компанийн бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө, ХЭХ-аас дэвшүүлсэн зорилт, шийдвэрийг биелүүлэхийн төлөө компанийн тухай хууль, компанийн “Дүрэм”, “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-аар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, ногдол ашиг хуваарилах, ХЭХ хуралдуулах, банкнаас зээл авах эрх олгох эсэх асуудлуудыг тус бүр хэлэлцэж гишүүдийн дийлэнх олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэн тогтоол гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан.

Тайлант хугацаанд компаниас их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно.

ҮЦГХТ-өөс 2018 оны 03-р сарын 28-ны өдөр гаргасан хураангуй судалгаагаар компани нь 460 хувьцаа эзэмшигчтэй байна.

Техник импорт ХК